БАТЛАВ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ц.МЯГМАРСҮРЭН
2025 оны ..05..... дугаар сарын ..17..-ний өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦӨЛЖИЛТИЙГ СААРУУЛАХ ЗОРИЛГООР ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ МОД, БУТ ТАРИХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Есөнзүйл сумын төвд байрлах 50,000 м^2 газарт хашаажуулалт хийж мод тарих

Д/д	Нэр	Ерөнхий шаардлага	Тайлбар
		Хашаа	
1	Төмөр торон хайс	3 метрийн урттай, 1,3 метр түүнээс дээш өндөртэй, хүрээний угольник төмрийн өргөн нь 4 см, төмрийн зузаан 2,5-3 мм, цайрдсан торны голч 3,8-4 мм багагүй	Урт-250 Өргөн -200 м
2	Төмөр хаалга	Өнгө дизиан сайтай машин техник болон хүн орж гарах боломжтой, том хаалга, 1 мал орохоргүй зүүн талд жижиг 1 баруун талд жижиг хаалга 1 байна 1. Том хаалганы шон 15-20 см диаметртэй турбаа байна. Төмрийн зузаан 2,5 мм дээш байна. 2. Том, хаалганы арамны квадрат 6 см хийх, квадрат төмрийн хэмжээ 3 см доошгүй, төмрийн зузаан 2,5 мм багагүй. 3. Жижиг хаалганы арамны квадрат 6 см хаалга хийх квадрат төмрийн хэмжээ 3 см доошгүй, төмрийн зузаан 2,5 мм багагүй.	том хаалга-1 ш жижиг хаалга- 2ш
3	Төмөр шон	Шонгийн квадрат төмрийн хэмжээ 8 см багагүй, зузааны хэмжээ 2,5 мм багагүй шон бүр хамгаалалтын таг, малгайтай байна	
4	Хашааны өнгө	Хашаа-шар, шон- хар өнгөтэй байна. /нар, чийгэнд тэсвэртэй зориулалтын будгаар будах/	
5	Нэмэлт шаардлага	Гагнуурын ажлыг стандартын дагуу цэвэр бат бөх гагнасан байна. Шонг газарт 50см суулгаж бетондож суурилуулах	
		Тарих мод	
6	Модны нэр төрөл	Улиас, хайлаас, суулгац тарих	
7	Стандарт шаардлага	MNS6141:2020 Навчит модны суулгац, Улиасны суулгац Ерөнхий шаардлага MNS6257:2011	
8	Техникийн шаардлага	• Мод үржүүлгийн газар эр улиасны мөчрөөр бойжуулан ургасан тарьц, суулгац байна.	

		• Үндэсний чийгийг алдагдуулахгүй байх, суулгацын үндэсний системийг хатахаас сэргийлж, чийгтэй үртэс бор шороотой гялгар уутанд хийж боосон байх • Гадна талын өнгө хэвийн, холтос нь шалбарч, гэмтээгүй, өвчин хөнөөлт шавжид өртөөгүй, нахиа задраагүй, мөчөр нь уян зөөлөн байна. • Үндэсний системийн хөгжил сайн, олон салаа үндэстэй байх
9	Тоо хэмжээ нас, өндөр	Улиас 200 ширхэг, 3-аас дээш настай байх 1,5 м-ээс дээш өндөртэй байх
10	Тоо хэмжээ нас, өндөр	Хайлаас 300 ширхэг, 3-аас дээш настай байх 50 см-ээс дээш өндөртэй байх
11	Хэлбэр	Зөв титэмтэй мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд нь ишний нийт уртын ¾ эзэлсэн байна
12	Гадаад байдал	Гадна талын өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа нь задраагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, үндэс нь бат бөх, өсөлт хөгжилт сайтай, 3 дээш үндэстэй, олон салаалсан үндэс ихтэй байх, өсөлт сайтай байх
13	Нэмэлт шаардлага	• Гарал үүслийн бичгийг тендерийн бичиг баримтад хавсарган ирүүлэх • Суулгацын чанар нь стандарт болон техникийн тодорхойлолтод нийцэхгүй бол захиалагч тал хүлээн авахгүй • Тээвэрлэлтийн зардлыг тендерт оролцогч тал бүтэн хариуцна • Мод суулгацын зааварчилгаа зөвлөмжийг өгөх • Улиас модыг хашааны урд, баруун хойд талаар нь тарих бөгөөд хайлаас модыг хашааны зүүн талаар дагуулж тарьсан байна.
Жич: Ачилт, буулгалт, угсралт, суурилуулалт, тээвэрлэлт, тариалалтын зардлыг тухайн аж ахуйн нэгж бүрэн хариуцах.		

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР